БАТЛАВ
ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.03 Хугацаа 60 минут **А хувилбар** Хэрлэн сум

Нийт оноо: 20 Анги: Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Болжмор**

Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа. Гэнэт өрөөсөн чих час хийв. "Хэн юм шидчихэв ээ" гэж гайхан ийш тийшээ харвал юу ч байсангүй. Чихээ гараараа дарж, нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа. "Хүүе, өвөл яахаараа боргоцой байдаг билээ?" гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана. Дүү:

-Энэ болжморууд хөлдөж үхэх нь ээ гэвэл ах:

-Хоёулаа үүр хийж өгье, өнөө орой л хийе гэв.

Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа, талхны үртэс тавилаа. Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан, үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой. Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад, бид бас баяслаа. /Davalgaa.mn 2016/

**1.** Эхэд юуны тухай өгүүлснийг бичээрэй./2 оноо/

........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................

**2.** Дараах өгүүлбэрийн цөм бүтцийг олж бичээд, тодорхойлно уу. /2 оноо/

Ээж будаа, талхны үртэс тавилаа.

........................................................................................................................
........................................................................................................................

**3.** "Чихээ гараараа дарж, нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа" гэсэн өгүүлбэрээс жинхэнэ нэр 4-ийг олж бичээрэй. /2 оноо/

........................................................................................................................

**4. "боргоцой"** гэсэн үгийг тийн ялгалын бүх нөхцөлөөр хувилгаж бичээрэй. /2 оноо/

........................................................................................................................
........................................................................................................................

**5. үндэс+л** гэсэн үгийг зөв холбож бичээд, дүрмийг нь тайлбарлаарай. /2 оноо/

........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................

6. Дараах үндэсний бичгээр бичсэн үгийг уншаад кириллээр хөрвүүлж бичээрэй.

/5 оноо/



............................................................................................

............................................................................................

............................................................................................

............................................................................................

............................................................................................

7. Уран зохиолын хичээл дээр үзсэн зохиолоосоо нэгийг сонгоод өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичээрэй. Үгийн тоо 40-50 /5 оноо/

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Д.БАЙГАЛМАА

БАТЛАВ
ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.03 Хугацаа 60 минут **В хувилбар** Хэрлэн сум

Нийт оноо: 20 Анги: Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Дугуй**

Батбаатар дугуй унаж сурахыг туйлаас хүсэх болов. Нэг өдөр ахынхаа дугуйг унаж үзэхээр мордоод явах гэтэл дугуйтайгаа ойчжээ. Гараа шалбалсныг тоосон ч үгүй дугуйгаа босгоод дахиад явахдаа хураалттай байсан түлээ мөргөж унав. Хүчтэй мөргөснөөс толгой нь дүйрч байжээ. Ах нь гүйж ирээд:

-Их өвдөв үү? Миний дүү дугуй унаж сурах болоогүй байна. Хойтонгоос унаж сурах хэрэгтэй гэв.

Ахыгаа явсны дараа Батбаатар "Заавал дугуй унаж сурна даа" гэж хатуу шийджээ. Орой болоход Батбаатар дугуйн дээрээ тогтохоор барахгүй ойрхон газар явдаг болжээ. Айлын хүүхдүүд түүнд баяр хүргэв. Ээж нь ирээд:

-Миний хүү овоо доо гээд духан дээр нь үнсэв.

-Би дугуйнаасаа олон унасан гэж Батбаатарыг хэлэхэд

-Ямар ч бэрхшээлийг давж чадвал юуг ч сурдаг юм гэж ээж нь захив. /Д.Давааням, 1984/

1.Эхэд юуны тухай өгүүлснийг бичээрэй./2 оноо/

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

2. Дараах өгүүлбэрийн цөм бүтцийг олж бичээд, тодорхойлно уу. /2 оноо/

Айлын хүүхдүүд түүнд баяр хүргэв.

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

**4.** "Орой болоход Батбаатар дугуйн дээрээ тогтохоор барахгүй ойрхон газар явдаг болжээ. Айлын хүүхдүүд түүнд баяр хүргэв" гэсэн өгүүлбэрээс жинхэнэ нэр 4-ийг олж бичээрэй. /2 оноо/

.......................................................................................................................................

**4. "түлээ"** гэсэн үгийг тийн ялгалын бүх нөхцөлөөр хувилгаж бичээрэй. /2 оноо/

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

**5. холтос+л** гэсэн үгийг зөв холбож бичээд, дүрмийг нь тайлбарлаарай. /2 оноо/

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

6. Дараах үндэсний бичгээр бичсэн үгийг уншаад кириллээр хөрвүүлж бичээрэй.

/5 оноо/



..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

7. Уран зохиолын хичээл дээр үзсэн зохиолоосоо нэгийг сонгоод өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичээрэй. Үгийн тоо 40-50 /5 оноо/

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Д.БАЙГАЛМАА